

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/007/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Сүхбаатар сум 2026 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn
	Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Э.БАЯРХҮҮ ТАНАА

2026.03.23 № СЭА-2026/007/НА-СТА-773
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрийн 36 арга хэмжээг санхүүжүүлэхээр 18,569,675.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 12,948,245.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 5,021,633.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 599,796.2 мянган төгрөгийг ХХС-ийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 15,888,313.3 мянган төгрөг буюу 85.6 хувьтай байгаа нь урсгал зардлыг 1,019,111.4 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 1,162,454.1 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийг 499,796.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад

4326050344³

хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Мандал сумын ЗДТГ-ын даргын 2025 оны А/11 дүгээр албан бичгээр Төрийн албаны зөвлөлд дэд бүтэц, хот төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг батлуулахаар хүргүүлсэн ч баталж ирүүлээгүй, сонгон шалгаруулалт зарлах боломжгүй гэх үндэслэлээр тайлант онд 2 албан хаагчийг дэд бүтэц хариуцсан гэрээт ажилтнаар томилж, цалингийн бус сүлжээгээр цалинжуулж, **69,243.9** мянган төгрөгийг тооцож олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Мандал сумын Засаг дарга нь тайлант онд 17 зорилт, 235 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 100 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,447,596.56	12,398,825.19
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,217,055.99	7,336,552.89
3	АВЛАГА	773,211.63	959,888.93
4	УРЬДЧИЛГАА	8,174.2	-
5	БАРАА МАТЕРИАЛ	4,449,154.73	4,102,383.37
6	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	40,920,871.79	46,015,737.77
7	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	40,920,871.79	46,015,737.77
8	Биет хөрөнгө	37,921,622.74	38,438,310.16
9	Биет бус хөрөнгө	2,999,249.04	7,577,427.6
10	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	53,368,468.35	58,414,562.96
11	НИЙТ ӨР ТӨЛБӨР	559,913.54	755,178.28
12	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	548,608.74	743,873.48
13	Өглөг	542,120.1	742,238.94
14	Урьдчилж орсон орлого	6,488.64	1,634.54
15	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,304.8	11,304.8
16	Урт хугацаат зээл	11,304.8	11,304.8
17	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	52,808,554.81	57,659,384.67
18	Засгийн газрын хувь оролцоо	52,808,554.81	57,659,384.67
19	Засгийн газрын оруулсан капитал	7,372,690.34	7,372,690.34
20	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	377,879	742,292.83
21	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	1,560,232.61	1,560,232.61
22	Хуримтлагдсан үр дүн	41,893,136.86	46,379,751.18
23	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,604,616	1,604,417.72
24	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	53,368,468.35	58,414,562.96

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	23,169,809.09	23,932,477.89
2	ТАТВАРЫН ОРЛОГО	12,909,317.93	12,782,696.98
3	Орлогын албан татвар	10,101,458.28	10,560,557.22
4	Хувь хүний орлогын албан татвар	10,645,108.12	11,291,851.81
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-543,649.84	-731,294.59
6	Хөрөнгийн албан татвар	828,574.26	880,110.39
7	Бусад татвар, төлбөр, хураамж	1,979,285.4	1,342,029.36
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,579,278.21	11,149,780.91
9	Тусламжийн орлого	-	315,685.37
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,681,212.94	-
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	13,328,238.01	16,659,622.96
12	УРСГАЛ ЗАРДАЛ	13,328,238.01	16,659,622.96
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,258,377.81	14,613,108.61
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,646,555.02	3,224,967.15
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	326,357.53	802,847.36
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,712,107.52	2,905,557.96
17	Хангамж, бараа материалын зардал	182,665.39	156,902.41
18	Нормативт зардал	550.00	-
19	Эд хогшил, урсгал засварын зардал	402,197.9	747,259.11
20	Томилолт, зочны зардал	13,346.56	17,215.3
21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,335,585.33	2,864,483.43
22	Бараа үйлчилгээний бусад зардал	3,639,012.56	3,893,875.9
23	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,069,860.2	2,046,514.34
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	9,841,571.08	7,272,854.93
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,309,505.66	2,813,279.99
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-3,309,505.66	-2,813,279.99
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	6,532,065.42	4,459,574.94

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	45,971,485.77		45,971,485.77
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-12,350.57		-12,350.57
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	45,959,135.2		45,959,135.2
4	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	80,875		80,875
5	Өмчид гарсан өөрчлөлт	236,479.19		236,479.19
6	Тайлант үеийн үр дүн	6,532,065.42		6,532,065.42
7	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	52,808,554.81		52,808,554.81
8	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	52,808,554.81		52,808,554.81
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	391,453.21		391,453.21
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	53,200,008.02		53,200,008.02
11	Тайлант үеийн үр дүн	4,459,376.65		4,459,376.65
12	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	57,659,384.67		57,659,384.67

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	20,337,868.97	18,699,922.47
2	ТАТВАРЫН ОРЛОГО	12,657,994.68	12,782,696.98
3	Орлогын албан татвар	10,101,458.28	10,560,557.22
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-543,649.84	-731,294.59
5	Хөрөнгийн албан татвар	828,574.26	880,110.39
6	Бусад татвар, төлбөр, хураамж	1,727,962.14	1,342,029.36
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	436,551.28	469,417.3
8	Газрын төлбөр	1,103,231.6	551,318.07
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	188,179.26	321,293.99
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,244,454.79	5,917,225.49
11	Нийтлэг татварын бус орлого	3,244,454.79	4,209,787.89
12	Тусламжийн орлого	-	92,237.6
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	1,615,200
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,435,419.5	-
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,863,704.24	14,585,974.5
16	УРСГАЛ ЗАРДАЛ	12,863,704.24	14,585,974.5
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,794,038.25	12,498,392.09
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,830,862.42	4,542,522.57
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	615,435.05	802,847.36
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,024,478.77	3,212,090.34
21	Хангамж, бараа материалын зардал	1,294,268.4	1,729,687.13
22	Нормативт зардал	1,100	3,184
23	Эд хогшил, урсгал засварын зардал	428,594.35	849,425.68
24	Томилолт, зочны зардал	12,626.56	17,017.2
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,314,485.9	1,000,194.86
26	Бараа үйлчилгээний бусад зардал	272,186.8	341,422.95
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,069,666	2,087,582.41
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,474,164.73	4,113,947.97
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	3,690,733.72	3,894,451.07
30	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,690,733.72	3,894,451.07
31	Дотоод эх үүсвэрээр	3,690,733.72	3,894,451.07
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-3,690,733.72	-3,894,451.07
33	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	50,000	100,000
34	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-50,000	-100,000
35	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,733,431.01	119,496.9
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,483,624.98	7,217,055.99
37	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,217,055.99	7,336,552.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	18,569,675.00	16,035,935.12	2,533,739.88	86.36
11	Татварын орлого	11,662,119.90	12,782,696.98	(1,120,577.08)	109.61
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	8,803,247.30	9,523,940.02	(720,692.72)	108.19
110002	Үйл ажиллагааны орлого	1,080,194.70	824,190.09	256,004.61	76.30
110003	Хөрөнгийн орлого	551,100.00	639,253.15	(88,153.15)	116.00
110004	Хөрөнгө борлуулсны орлого	294,800.00	304,468.55	(9,668.55)	103.28
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(731,294.60)	(731,294.59)	(0.01)	100.00
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	506,765.20	634,175.32	(127,410.12)	125.14
113002	Бууны албан татвар	12,960.00	13,199.00	(239.00)	101.84
113004	Малд ногдуулах албан татвар	225,735.10	232,736.07	(7,000.97)	103.10
118001	Улсын тэмдэгийн хураамж	148,800.00	188,734.23	(39,934.23)	126.84
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	103,987.60	74,228.07	29,759.53	71.38
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	186,000.00	206,455.00	(20,455.00)	111.00
118101	Газрын төлбөр	227,486.40	364,065.80	(136,579.40)	160.04
118102	Дуудлага худалдаа	50,000.00	187,252.27	(137,252.27)	374.50
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	191,944.10	313,668.81	(121,724.71)	163.42
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	4,395.00	2,256.00	2,139.00	51.33
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	4,999.10	5,069.19	(70.09)	101.40
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1,000.00	300.00	700.00	30.00
12	Татварын бус орлого	6,907,555.10	3,253,238.14	3,654,316.96	47.10
120003	Торгуулийн орлого	507,000.00	1,014,280.77	(507,280.77)	200.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	60,000.00	297,520.51	(237,520.51)	495.87
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	6,480.00	40,119.00	(33,639.00)	619.12
120009	Бусад орлого	190,000.00	286,117.86	(96,117.86)	150.59
122005	Төсвөөс санхүүжих	4,131,924.20	-	4,131,924.20	-
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	2,012,150.90	1,615,200.00	396,950.90	80.27
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,569,675.00	15,888,313.26	2,681,361.74	85.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,948,245.60	11,929,134.15	1,019,111.45	92.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,901,792.70	9,893,181.70	1,008,611.00	90.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,400,185.10	3,226,633.77	173,551.33	94.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	430,276.00	394,738.11	35,537.89	91.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,303,284.50	2,908,037.20	395,247.30	88.03
2104	Хангамж, бараа материалын	146,742.50	105,504.72	41,237.78	71.90

	зардал				
2105	Нормативт зардал	3,184.00	3,184.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	897,307.00	869,276.11	28,030.89	96.88
2107	Томилолт, зочны зардал	27,834.20	17,017.20	10,817.00	61.14
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,243,584.80	2,079,218.49	164,366.31	92.67
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	449,394.60	289,572.10	159,822.50	64.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,046,452.90	2,035,952.45	10,500.45	99.49
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,848,041.40	1,848,041.40	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	198,411.50	187,911.05	10,500.45	94.71
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,021,633.20	3,859,179.11	1,162,454.09	76.85
220001	Барилга байгууламж	3,863,882.60	3,215,593.70	648,288.90	83.22
221001	Их засвар	368,920.50	58,850.00	310,070.50	15.95
222001	Тоног төхөөрөмж	248,295.00	215,608.75	32,686.25	86.84
223001	Бусад хөрөнгө	540,535.10	369,126.66	171,408.45	68.29
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	599,796.20	100,000.00	499,796.20	16.67
230001	Эргэж төлөгдөх зээл	599,796.20	100,000.00	499,796.20	16.67
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	7,130,749.96	(7,130,749.96)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	7,237,021.77	(7,237,021.77)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	187.00	183.00	4.00	97.86
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	5.00	5.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	5.00	5.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	91.00	89.00	2.00	97.80
620001	Удирдах ажилтан	15.00	15.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	45.00	43.00	2.00	95.56
620003	Үйлчлэх ажилтан	26.00	26.00	-	100.00
620004	Гэрээт ажилтан	5.00	5.00	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	91.00	89.00	2.00	97.80
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	29.00	27.00	2.00	93.10
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	45.00	45.00	-	100.00
650010	Гэрээт ажилтан	5.00	5.00	-	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	12.00	12.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	101,357.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	101,357.60
122	Тусламжийн орлого	101,357.60
1221	Хандив тусламж /дотоод/	101,357.60
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	101,357.60
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,701.54
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,877.48
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	83,778.58
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	99,127.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	99,127.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	99,127.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,058.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	236.67
2104	Хангамж, бараа материалын зардал	29,002.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,979.57
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,850.85
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	2,229.91
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(2,229.91)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(2,229.91)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

2025 оны сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт **291,800.8** мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс **13,230.4** мянган төгрөгийн алдааг залруулж, **3,528.6** мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, **167,798.5** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, **107,243.3** мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх **7** зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар **65,102.6** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, **91,900.3** мянган төгрөгийн зөрчилд **3** зөвлөмж хүргүүлсэн байна.

Үүнээс:

1. Бие даасан дүгнэлт өгсөн ААТҮГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар:

Сумын ТТЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдэж, бие даасан дүгнэлт өгсөн Тохилог хараа ААТҮГ-ын санхүүгийн тайланд **Өөрчлөлтгүй**, Мандал энерго ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд **Хязгаарлалттай** дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт **90,117.2** мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс **13,230.4** мянган төгрөгийн алдааг залруулж, **360.0** мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, **76,526.8** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, **1** зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар **2** зөвлөмж өгсөн.

2. Сумын ТТЗ-ийн түвшний санхүүгийн тайлангийн аудитаар:

Аудитаар нийт **201,683.6** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **3,168.6** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **91,271.7** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, **107,243.3** мянган төгрөгийн зөрчлийг арилгах **6** зөвлөмж хүргүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар **65,102.6** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, **91,900.3** мянган төгрөгийн зөрчилд **1** зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **171,327.1** мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс **78,567.2** мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

1. Төлбөрийн акт:

1. Цалин, улирлын үр дүнгийн урамшууллыг **3,168.6** мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна. Үүнд:

- **Сумын ЗДТГ:** Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхтүвшинд тушаал шийдвэргүйгээр 3 дугаар улирлын үр дүнгийн урамшуулалд **769.5** мянган төгрөг олгосон,
- **Түнхэл Захирагчийн алба:** Нягтлан бодогч Д.Ариунжаргалд мөнгөн урамшууллыг **233.8** мянган төгрөгөөр илүү тооцож олгосон,

- **Энх мэнд сувилал ААТҮГ:** Захирал А.Энхбилэгт ээлжийн амралттай нь давхардуулан 2,165.3 мянган төгрөгийн цалин тооцож олгосон.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалин, үр дүнгийн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Албан шаардлага:

1. ЗДҮАМХХ: Тус сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй арга хэмжээг санхүүжүүлж, У.Наранцэцэгт 2,000.0 мянган төгрөг, Гавьяат тамирчин Б.Ариунцэцэгт 10,000.0 мянган төгрөг, нийт **12,000.0** мянган төгрөгийн урамшуулал олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сумын ИТХ-ын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн “Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах тухай” 28 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

2. ЗДНХ: Сумын Засаг даргын 2025 оны А/03 дугаар захирамжаар баталсан "Гал түймэр гарах эрсдэлийг бууруулах нэгдсэн арга хэмжээ", А/131 дүгээр захирамжаар баталсан "Экологийн цагдаагийн албаны шалгалт", А/425 дугаар захирамжаар баталсан "Нийтийн эзэмшлийн талбай, авто замын цас мөс цэвэрлэх" арга хэмжээний **9,334.8** мянган төгрөгийн шатахууны тайланг сумын ЗДТГ-ын нягтлан бодогч хянаж, хүлээж аваагүй.

Эдгээр нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 6 дугаар зүйлийн 6.3 дахь “Нөөц хөрөнгийн зарцуулалт, тайлагналтыг тухайн шатны Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч хариуцан гүйцэтгэнэ.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлын тайланг хянаж хүлээн авч байх албан шаардлага хүргүүлэв.

3. Баяр наадмын зардал: Тус зардлын батлагдсан төсвийг **3,136.4** мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Сумын 2025 оны төсөв батлах тухай” 09 дүгээр тогтоолыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

4. Батлагдсан төсвийг зориулалт бусаар зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй дараах **8,229.4** мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- **ИТХ:** Цалингийн зардлын батлагдсан төсвөөс **2,701.6** мянган төгрөгийг ажил олгогчийн төлөх НДШ-ийн зардалд гүйлгэн зарцуулсан,
- **Ойн анги:** Ажил олгогчийн төлөх НДШ-ийн зардлын батлагдсан төсвөөс **2,463.8** мянган төгрөгийг даатгуулагчаас төлөх НДШ-ийн зардалд гүйлгэн зарцуулсан,
- **ЗДТГ:** Бараа үйлчилгээний бусад зардлаас өглөөний уулзалт ярилцлагын төлбөр 540.0 мянган төгрөг, Хард, лан case-ийн 613.0 мянган төгрөг, нийт **1,153.0** мянган төгрөгийн төлбөрийг гүйцэтгэсэн,
- **Түнхэл 3А:** Бараа үйлчилгээний бусад зардлаас мэргэшсэн нягтлан бодогчийн сургалтын төлбөр 504.0 мянган төгрөг, Си Ти Эс ХХК-ийн сургалт, вирусийн программын төлбөр 453.0 мянган төгрөг, нийт **957.0** мянган төгрөгийн төлбөрийг гүйцэтгэсэн,
- **Хэрх 3А:** Бараа үйлчилгээний бусад зардлаас мэргэшсэн нягтлан бодогчийн сургалтын төлбөр 504.0 мянган төгрөг, Си Ти Эс ХХК-ийн сургалтын төлбөр 450.0 мянган төгрөг, нийт **954.0** мянган төгрөгийн төлбөрийг гүйцэтгэсэн.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

5. Мандал сум дахь Сум дундын шүүхийн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 149/ШШ2025/00256 дугаартай шийдвэрээр гэрээт байгаль хамгаалагч /хууль бусаар ажлаас халагдсан нь тогтоогдсон/ О.Энхбатад ажилгүй байсан хугацааны цалин, НДШ, томилолтын зардал болох **6,474.5** мянган төгрөгийг тус байгууллагын төсвөөс барагдуулсан боловч буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх “... өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ.”, 103.3 дахь “Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна.”, Иргэний тухай хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 дахь “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын төсвөөс барагдуулсан төлбөрийг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх албан шаардлага хүргүүлэв.

6. Архив, бичиг хэргийн ажилтны албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн Б.Номингоор хавсран гүйцэтгүүлж, **5,376.4** мянган төгрөгийн нэмэгдлийг тооцож олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт болон сумын ЗДТГ-ын даргын 2025 оны А/12 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан “Архив, бичиг хэргийн ажилтан”-ы албан тушаалын тодорхойлолттой тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажиллагсдаар албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийг гүйцэтгүүлж, төсвийг хэмнэлттэй үр ашигтай зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

7. Ойн ангийн дарга Р.Нарангийн ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэлгүйгээр **3,178.3** мянган төгрөгийн урамшууллыг тооцож олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2 дахь “Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно: 1.2.1: төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид;” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үнэлүүлж, түүнийг үндэслэн гарсан тушаал шийдвэрээр үр дүнгийн урамшууллыг тооцож олгож байх албан шаардлага хүргүүлэв.

8. Орлогын төлөвлөгөөг дараах 2 байгууллага нь **42,141.9** мянган төгрөгөөр тасалсан. Үүнд:

- Түнхэл тосгоны Захирагчийн алба нь туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг **1,200.0** мянган төгрөгөөр,
- Мандал шинэ агротехник ААТҮГ нь үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг **40,941.9** мянган төгрөг.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь “*үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах*” гэсэн заалтууд болон Мандал сумын ИТХ-ын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн “Мандал шинэ агротехник ААТҮГ-ын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн тухай” 22 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогын төлөвлөгөөг бодитой батлуулан, бүрэн биелүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

9. Сумын ЗДТГ нь өмнөх онд үүссэн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгалгүйгээр байгууллагын 2024 оны шилдэг албан хаагчийн шагнал Н.Сэлэнгэд 500.0 мянган төгрөг, Ч.Мөнхтүвшинд 300.0 мянган төгрөг, М.Отгонзулд 600.0 мянган төгрөг, нийт **1,400.0** мянган төгрөгийг тайлант оны төсвөөс төлж, барагдуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.3: бүх өр төлбөр*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах, авлага өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаагүй **101,668.7** мянган төгрөгийг ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

- **Ойн анги:** “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн хурлын тэмдэглэл техникийн комиссын акт, дүгнэлтгүйгээр 5,146.3 мянган төгрөгийг тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэлд зарцуулсан,
- **ЗДТГ:** “Тарни 8-р багт хашаа барих” арга хэмжээний 12,778.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж, ажил гүйцэтгүүлсэн боловч гэрээг дүгнэж, хүлээж авсан талаар холбогдох анхан шатны баримтгүй,
- **БХНСАХ**-ий зардлаас санхүүжүүлсэн 55,944.4 мянган төгрөгийн Усалгааны машины тээврийн хэрэгслийн гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй, **Баяр наадмын зардлын** батлагдсан төсвөөс төсвөөс үлээвэр хөгжим 2,000.0 мянган төгрөг, тайз дэлгэц түрээс 20,000.0 мянган төгрөг, хөтлөгчийн хөлс 2,000.0 мянган төгрөг, хоолой бичлэг панограмм 3,800.0 мянган төгрөг зэрэг нийт **27,800.0** мянган төгрөгийн гэрээг байгуулж, төлбөрийг шилжүүлсэн боловч гүйцэтгэлийн талаарх холбогдох анхан шатны баримтгүй байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэх зөвлөмж хүргүүлэв.

2. Авлагатай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Мандал шинэ агротехник ААТҮГ нь өмнөх онд үүссэн **5,574.6** мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, Энх мэнд сувилал ААТҮГ нь тайлант хугацааны эцэст харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх “*Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана ...*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”, 20.2.6 дахь “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Он дамжсан авлага, өр төлбөрт дүн шинжилгээ хийж бууруулах үр нөлөө бүхий арга хэмжээ авах, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж байх зөвлөмж хүргүүлэв.

3. Хуримтлагдсан ашиг, алдагдалтай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Мандал шинэ агротехник ААТҮГ нь тайлант онд үйл ажиллагааны үр дүнгээр 9,321.1 мянган төгрөгийн алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж чадаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр **өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ ...**” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Тус газрын үйл ажиллагаанд санхүүгийн шинжилгээ хийж, өөрийгөө санхүүжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Дээрх **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	4	108,215.6			3	24,471.2	1	83,744.4				
ЗДТГ	6	27,951.4	1	769.5	4	14,403.9	1	12,778.0				
ИТХ	1	2,701.6			1	2,701.6						
Ойн анги	2	10,788.4			1	5,642.1	1	5,146.3				
Түнхэл захирагчийн алба	3	2,390.8	1	233.8	2	2,157.0						
Хэрх захирагчийн алба	1	954.0			1	954.0						
Мандал шинэ агротехник ААТҮГ	3	46,516.5			1	40,941.9	2	5,574.6				

Энх мэнд сувилал ААТҮГ	2	2,165.3	1	2,165.3			1	-			
Дүн	22	201,683.6	3	3,168.6	13	91,271.7	6	107,243.3			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилт								
ТТЗ	2	157,002.9			1	65,102.6	1	91,900.3
Дүн	2	157,002.9			1	65,102.6	1	91,900.3
Нийт дүн	2	157,002.9			1	65,102.6	1	91,900.3